



**“Хуульчийн эрх зүйн байдлын тухай
хуулийн хэрэгжилт ба Хуульчдын
Холбоон дахь шүүгчдийн гишүүнчлэл,
үйл ажиллагаа”-ны талаарх лавлагаа**

ЛАВЛАГАА

**Шүүхийн ерөнхий
зөвлөлийн гишүүн
О.Зандраагийн
захиалгаар
бэлтгэв.**

Агуулга

| | |
|--|----|
| Удитгал | 2 |
| I. Шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх олон улсын хэм хэмжээ | 3 |
| 1.1. Шүүхийн бие даасан байдлын тухай Монреалийн түгээмэл тунхаглал, 1983 | 3 |
| 1.2. НҮБ-ын 1985 оны “Шүүхийн бие даасан байдлын үндсэн зарчмууд”-ын | 3 |
| 1.3. Шүүгчдийн статусын тухай Европын дүрэм, 1998 | 4 |
| 1.4. Шүүгчдийн түгээмэл дүрэм, 1999 | 4 |
| 1.5. Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд, 2002 | 4 |
| II. Гадаадын зарим улс дахь шүүгчдийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх зохицуулалт | 5 |
| Дүгнэлт..... | 12 |
| Ном зүй | 13 |



Удиртгал

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /цаашид “ХЭЗБТХ” гэх/ 2012.03.07-ны өдөр батлагдаж, 2013.04.15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж 3 жил гаруй хугацаанд үйлчилж байна. Тус хуульд Хуульчдын холбоонд шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульч гишүүнчлэлтэй байхаар заасан. Түүнчлэн мөн хуульд шүүгчтэй холбоотой дараах харилцааг зохицуулсан. Үүнд:

1. ХЭЗБТХ-ийн 44.4: “Шүүгч өөрийн нэр хүнд, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжихээс бусад зорилгоор мэргэжлийн болон төрийн бус бусад байгууллагад эвлэлдэн нэгдэхийг хориглоно.”
2. ХЭЗБТХ-ийн 46.6: “Хуульчдын их хурлын төлөөлөгчдийн 40 хувь нь шүүгч, прокурорын дундын төлөөлөл байна.”
3. ХЭЗБТХ-ийн 47.3.5: “Хуульчдын холбооны Ерөнхийлөгч нь Хуульчдын холбооны шүүгчдийн хорооны удирдах зөвлөлөөс өргөн мэдүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс сонгож, Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгоно.”
4. ХЭЗБТХ-ийн 51.2: “Хуульчдын холбооны хяналтын зөвлөл нь шүүгч, прокурор, өмгөөлөгчөөс бүрдсэн таван гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийг гурван жилийн хугацаагаар томилно.”
5. ХЭЗБТХ-ийн 52.1: “Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо нь Хуульчдын холбооны шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны гишүүд, түүнчлэн хуульч профессоруудын төлөөлөл оролцсон 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.” Мөн хуулийн 52.2: “Шалгалтын хорооны бүрэлдэхүүнийг Хуульчдын холбооны Зөвлөл батална.”
6. ХЭЗБТХ-ийн 54.3: “Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны гишүүн нь бүх шатны шүүгчид нэр дэвшиж байгаа хуульч болон Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр нэр дэвшиж байгаа шүүгч, прокурор, өмгөөлөгчийн зан байдлын талаар дүгнэлт гаргах шинжээчээр ажиллаж болно.”
7. ХЭЗБТХ-ийн 56.1: “Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо нь Хуульчдын холбооны шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн болон бусад мэргэшлийн чиглэлээр байгуулагдсан хуульчдын хорооны төлөөлөгчдөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.” Мөн зүйлийн 56.2: “Хуульчдын эрхийг хамгаалах хороонд шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны төлөөлөл тус бүр гурав, бусад хуульчдын хороодын нийт төлөөлөл дөрөв байна.” Мөн зүйлийн 56.5: “Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран комисс байгуулна.”
8. ХЭЗБТХ-ийн 60.1: “Хуульд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс байгуулагдсан мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд Хуульчдын холбооны төлөөлөл орно.” Мөн зүйлийн 60.2: “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.2-т заасны дагуу шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Хуульчдын холбоо гаргана.”
9. ХЭЗБТХ-ийн 63.8: “Мэргэжлийн хариуцлагын хороо нь маргааныг таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх ба бүрэлдэхүүнд шүүгч гурав, прокурор, өмгөөлөгч тус бүр нэг байна.” Мөн хуулийн 64.5.2, 64.6-д зааснаар Мэргэжлийн хариуцлагын хороо шүүгчийн Хуульчийн мэргэжлийн дүрмийг

зөрчсөн тухай болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэнтэй холбоотой үүссэн маргааныг бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч гаргана.

Дээрх зохицуулалт нь Хуульчдын холбоон дахь шүүгчдийн гишүүнчлэл, үйл ажиллагаатай шууд холбогдож байх бөгөөд энэ судалгаанд тус асуудлыг голчлон авч үзлээ. Энэ хүрээнд дараах бүтцээр бүх шатны шүүхийн шүүгчид Монголын Хуульчдын холбооны гишүүнчлэлтэй байгаа нь үндэсний хууль тогтоомж болон олон улсын нийтээр дагаж мөрдөж буй хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийхийг зорилоо. Үүнд: 1/Шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх олон улсын хэм хэмжээ, 2/Гадаадын зарим улс дахь шүүгчдийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх зохицуулалт, 3/Монгол Улсын шүүгчдээс авсан асуулгын дүн.

I. Шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх олон улсын хэм хэмжээ

1.1. Шүүхийн бие даасан байдлын тухай Монреалийн түгээмэл тунхаглал, 1983¹

Шүүхийн бие даасан байдал, дэлхийн энх тайвны олон улсын холбооноос Канадын Монреаль хотноо 1983.06.10-ны өдөр зохион байгуулсан Шүүхийн бие даасан байдлын асуудлаарх дэлхийн анхны хурлын хаалтын чуулганд “Шүүхийн бие даасан байдлын тухай Монреалийн түгээмэл тунхаглал”-ыг санал нэгтэй баталсан. Тус тунхаглалд шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- 2.10. Шүүгч нь цаг ямагт шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, шүүхийн нэр хүндийг хадгалахад өөрөө анхаарна. Энэ зарчмын дагуу шүүгчид нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх эрхтэй.

1.2. НҮБ-ын 1985 оны “Шүүхийн бие даасан байдлын үндсэн зарчмууд”-ын зохицуулалт²

Тус баримт бичгийг 1985.08.26-1985.09.06-нд Милан хотноо болсон НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялтанг хүмүүжүүлэх 7 дугаар чуулганаас баталсан бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985.11.29-ний өдрийн 40/32 тоот тогтоол болон 1985.12.13-ны өдрийн 40/146 тоот тогтоолоор дэмжиж зөвшөөрсөн. Түүнд шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлын талаар авч үзсэн байна. Энэ зарчимд шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрх, шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны эсрэг гомдлыг хянан шийдвэрлэх асуудлын талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- 8. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын дагуу бүх шатны шүүгчид нь бусад иргэний адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх эрхтэй. Энэ эрхээ эдлэхдээ шүүгчид шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулахгүй байх, шүүн таслах үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагааг хангах шаардлагатай.
- 17. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны эсрэг гомдлыг шударга, зохистой үе шатаар авч хэлэлцэнэ. Шүүгч нь шударгаар шүүлгэх эрхтэй. Шүүгчтэй

¹ Montreal Universal Declaration on the Independence of Justice (the First World Conference on the Independence of Justice held at Montreal (Quebec, Canada) on June 10th, 1983) <http://www.iwjp.org/montreal-declaration>

² Basic Principles on the Independence of the Judiciary, 1985 <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/IndependenceJudiciary.aspx>

холбоотой хянан шалгах үйл ажиллагааны үе шат нь шүүгч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нууц байна.

1.3. Шүүгчдийн статусын тухай Европын дүрэм, 1998³

Европын зөвлөлөөс 1998 оны 7 дугаар сарын 8-10-ны өдөр зохион байгуулсан Европын шүүгчдийн статусын асуудлаарх олон талт уулзалтын оролцогсад тус дүрмийг баталсан. Тус дүрэмд шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- 1.7. Энэхүү дүрмээр шүүгчийн байгуулсан мэргэжлийн холбоод нь бүх шүүгчийн чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийн илэрхийлэл болохыг хүлээн зөвшөөрч байна. Түүнчлэн эдгээр холбоод нь шүүгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэдгээрт нөлөөлөх боломжтой байгууллага, албан тушаалтны өмнө хамгаалахад зохих хувь нэмэртэй оролцохыг онцолж байна. Энэ ёсоор шүүгчид мэргэжлийн холбоо байгуулах, тийм холбоодод элсэхийг хориглож болохгүй.
- 1.8. Шүүгчид нь шүүхийн төсөв, шүүхийн захиргаатай холбоотой аливаа шийдвэр болон тэдгээр шийдвэрийг орон нутаг, үндэсний түвшинд хэрэгжүүлэхтэй холбоотой асуудалд төлөөлөгчөөрөө дамжуулан оролцоно. Энэ ёсоор нь шүүхийн төсөв, шүүхийн захиргаатай холбоотой асуудалд шүүхийн захиргааны байгууллага нь шүүхийн төлөөлөгчийн үүрэгтэй оролцоно.

1.4. Шүүгчдийн түгээмэл дүрэм, 1999⁴

Энэхүү түгээмэл дүрмийн төслийг дэлхийн олон орны шүүгчид боловсруулсан. Энэ дүрэм нь тэдний ажлын үр дүн бөгөөд үүнийг Олон улсын Шүүгчдийн Холбооны гишүүн холбоодоос зайлшгүй дагаж мөрдөх үндсэн хэм хэмжээ болгон баталсан. Тодруулбал, 1999.11.17-ны өдөр Тайван улсын Тайбэй хотод болсон Олон улсын Шүүгчдийн холбооны ерөнхий зөвлөлийн хуралдаанаар төлөөлөгчид дээрх дүрмийг баталсан. Тус дүрэмд шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- **12 дугаар зүйл. Шүүгчдийн холбоо**
Шүүгчид нь өөрсдийн хууль ёсны эрх ашгаа хамгаалах, шударга ёс, ёс зүй, эрх ашгийнхаа төлөө эвлэлдэн нэгдэж, мэргэжлийн холбоо байгуулж болно.

1.5. Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд, 2002⁵

Шүүгчийн ёс зүйн Бангалорын дүрмийн төслийг 2001 онд шүүхийн бүрэн бүтэн байдлыг бэхжүүлэх асуудлаарх шүүгчдийн бүлэг баталсан бөгөөд 2002 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдөр Гааг хотноо болсон ерөнхий шүүгчдийн дугуй ширээний уулзалтаар хянан баталсан. Энэхүү Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмуудад шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- 4.6. Шүүгч нь энгийн иргэний адил дуу хоолой, үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх, эвлэлдэн нэгдэх эрхтэй боловч шүүх байгууллагын нэр төрийг хэлбэрэлтгүй хамгаалан, шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг чанд сахина.

³ European Charter on the statute for judges (8-10 July 1998) and Explanatory Memorandum to the European Charter on the statute for judges (8- 10 July 1998)

https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/evaluations/round4/European-Charter-on-Statute-of-Judges_EN.pdf

⁴ The Universal Charter of the Judge (adopted by the International Association of Judges on 17 November 1999, Taipei (Taiwan)

<https://www.domstol.dk/om/otherlanguages/english/publications/Publications/The%20universal%20charter%20of%20the%20judge.pdf>

⁵ The Bangalore Principles of Judicial Conduct, 2002

http://www.unodc.org/pdf/crime/corruption/judicial_group/Bangalore_principles.pdf

Эндээс дүгнэн үзэхэд, Монгол Улсын бүх шатны шүүхийн шүүгчид Хуульчдын холбооны гишүүн байх нь шүүгчдийн эвлэлдэн нэгдэх эрхийн бодит илэрхийлэл байх бөгөөд дээр дурдсан олон улсын нийтээр дагаж мөрдөж буй хэм хэмжээнд нийцэж байна.

Энэ хүрээнд шүүгчид Хуульчдын холбооны гишүүн байх, түүний үйл ажиллагаанд оролцох нь шүүх байгууллагын нэр төр, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах явдалд сөргөөр нөлөөлөх ёсгүй бөгөөд одоогийн нөхцөлд ийм нөлөөлөл тогтоогдоогүй байна.

II. Гадаадын зарим улс дахь шүүгчдийн эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх зохицуулалт

Энэ хүрээнд АНУ, Канад, Шинэ Зеланд, Израиль, Хонг Конг (БНХАУ)-ийн зохицуулалтыг авч үзэв.

| Д/д | Улсын нэр | Барын холбооны зохицуулалт | |
|-----|----------------------|--|---|
| | | Шүүгчийн гишүүнчлэл | Шүүгчийн эсрэг гомдлын зохицуулалт |
| 1. | АНУ | Америкийн Барын холбоо нь шүүхийн нэгжтэй. ⁶ Тус холбоонд шүүгч, хуульч, шүүхийн менежерүүд, хуулийн багш нар, зохиогч, нийтлэгчид, хуулийн оюутнууд гишүүнээр элсэхэд нээлттэй. ⁷ | Шүүгчийн эсрэг гомдлыг Америкийн Барын холбоо зохицуулдаггүй. Ийм гомдлыг тухайн шүүгчийн оршин суугаа муж дахь шүүгчийн сахилгын хороонд гаргах ёстой. ⁸ |
| | АНУ-ийн Нью-Йорк муж | Нью-Йорк мужийн Барын холбоонд Нью-Йоркийн хуулийн мэргэжилтэн бүхэн гишүүнээр элсэхэд нээлттэй. Нью Йоркоос өөр газар ажиллагч хуулийн мэргэжилтний хувьд Барын холбоонд дэд гишүүнчлэлтэй байх боломжтой. ⁹ Нью-Йоркийн Барын холбоо нь зөвхөн Нью-Йоркийн болон АНУ-ын шүүхийн шүүгчдэд нээлттэй шүүхийн хэсэгтэй. | Нью-Йоркийн Барын холбоо нь шүүгчийн эсрэг гомдлыг хариуцдаггүй. Холбооны шүүхийн шүүгчдийн эсрэг гомдлыг АНУ-ын 2 дугаар тойргийн давж заалдах шатны шүүхийн туслахад гаргана. ¹⁰ Нью-Йорк хотын шүүгчдийн эсрэг гомдлыг Нью-Йоркийн шүүгчийн ёс зүйн хороонд гаргана. Тус хороо нь шүүгч, хуульч, олон нийтийн төлөөлөл бүхий 3 гишүүнээс бүрдэнэ. ¹¹ |
| 2. | Канад | Шүүгчид нь Канадын Барын холбооны гишүүн байх эрхтэй. ¹² Барын холбоо нь Шүүхийн нөхөн олговрын хороотой бөгөөд тус хороо нь шүүхийн нөхөн олговрыг тодорхойлох үйл явцын шударга байдлыг дэмждэг. ¹³ | Холбооны шүүхийн шүүгчдийн эсрэг гомдлыг шүүхийн зөвлөлд гаргана. ¹⁴ Тус зөвлөл нь Канадын Барын холбоонд харьяалагддаггүй. |

⁶ American Bar, <http://www.americanbar.org/groups/judicial.html>

⁷ American Bar, <http://www.americanbar.org/groups/judicial/membership.html>

⁸ American Bar, http://www.americanbar.org/groups/professional_responsibility/resources/resources_for_the_public.html

⁹ The Bylaws of the New York Bar Association, available at: <http://www.nysba.org/Bylaws/>

¹⁰ New York City Bar, *How to Complain about Lawyers and Judges in New York City*, June 2012, page 8. Available at: <http://www.nybar.org/for-the-public/about-lawyers-and-judges/complaints-about-lawyers-and-judges-how>

¹¹ Мөн тэнд, р.7

¹² Canadian Bar Association, <http://www.cba.org/Membership/Membership-Information/Membership-Categories>

¹³ Canadian Bar Association, <http://www.cba.org/Sections/Judicial-Compensation-and-Benefits-Committee>

¹⁴ Canadian Judicial Council, http://www.cjc-ccm.gc.ca/english/conduct_en.asp?selMenu=conduct_complaint_en.asp#wcymaca

| | | | |
|----|-------------|--|--|
| 3. | Шинэ Зеланд | Шинэ Зеландын Барын холбооны бүрэн эрхт гишүүн нь хуульчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуульчид байна. ^{15, 16} Тэтгэвэрт гарсан шүүгчид хуульчийн үйл ажиллагаа эрхлээгүй гишүүн байж болно. Гэхдээ Шинэ Зеландын Барын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч болох боломжгүй. ¹⁷ Шүүхийн ёс зүйн удирдамжаар Шинэ Зеландын Барын холбооны гишүүнчлэлтэй байхыг хориглодоггүй. ¹⁸ | Шүүгчдийн тухай гомдлыг Шинэ Зеландын Барын холбоо бус Шүүхийн ёс зүйн комиссарын газарт гаргана. ¹⁹ Шинэ Зеландын Барын холбоо нь түүний гишүүдтэй холбоотой гомдлыг хариуцдаггүй. |
| 4. | Израиль | Израилийн Барын холбоо нь бие даасан хуулийн этгээд юм. ²⁰ Барын холбооны 1961 оны дүрмийн 52a (а)-д зааснаар Барын холбооны гишүүн хуульч шүүгчээр томилогдсон бол тийнхүү томилогдсоноос хойш шүүгчийн үүргээс чөлөөлөгдөх хүртэл гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ. | Шүүгчид нь Барын холбооны гишүүн биш. |
| 5. | Хонг Конг | Хонг Конгийн Барын холбоо нь шүүх дэх хуульчийг түүний гишүүн болохыг зөвшөөрдөг. Ингэхдээ нийгмийн статусын хувьд хамаарах гишүүнчлэл олгох бөгөөд ийм гишүүн нь саналын эрхгүй байна. ²¹ | Хонг Конгийн Барын холбоо нь шүүхэд төлөөлөх эрхтэй хуульчийн ёс зүйн зөрчлийн асуудлыг хариуцдаг. Шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг тухайн шүүхийн тамгын газраар дамжуулан Ерөнхий шүүгч буюу Шүүхийн тэргүүнд гаргана. ²² |

Дээр авч үзсэн таван улсад шүүгч нь Хуульчдын холбооны гишүүн байх эсэх асуудлыг төстэй байдлаар зохицуулсан байна. Тодруулбал, дээр дурдсан улсуудад ихэвчлэн шүүгчийг Хуульчдын холбооны гишүүн байхыг зөвшөөрөх хэдий ч шүүгчтэй холбоотой гомдлыг Хуульчдын холбоо бус шүүхийн ёс зүйн хороо буюу түүнтэй адилтгах байгууллага, ерөнхий шүүгч хариуцахаар зохицуулсан байна.

Зарим судлаачийн хувьд шүүгчийг хуульчдын холбооны гишүүнчлэлийг орхих нь зүйтэй гэх саналыг дэвшүүлсэн байдаг. Үүнийгээ хуульчдын холбоон дахь гишүүнчлэл нь шүүгчийн ёс зүйн дүрмээр хүлээсэн үүрэгтэй нь зөрчих эрсдэлтэй холбон тайлбарлажээ.

23

¹⁵ New Zealand Bar Association, <https://www.nzbar.org.nz/>

¹⁶ New Zealand Bar Association, https://www.nzbar.org.nz/Category?Action=View&Category_id=129

¹⁷ New Zealand Bar Association, https://www.nzbar.org.nz/Category?Action=View&Category_id=131

¹⁸ New Zealand "Guidelines for Judicial Conduct"

<https://www.courtsofnz.govt.nz/old/business/guidelines/guidelines-for-judicial-conduct/Guidelines-for-Judicial-Conduct-March-2013.pdf>

¹⁹ New Zealand Office of the Judicial Conduct Commissioner, <http://www.jcc.govt.nz/>

²⁰ Israel Bar Association, http://www.israelbar.org.il/english_index.asp

²¹ Hong Kong Bar Association, <http://www.hkba.org/content/rules-regulations>

²² Hong Kong, "Complaints against a Judge's Conduct",

http://www.judiciary.gov.hk/en/crt_services/pphl/pdf/complaintsjioleaflet.pdf

²³ Randall T. Shepard, Judicial Professionalism and the Relations between Judges and Lawyers, 14 Notre Dame J.L. Ethics & Pub. Pol'y 223 (2000). Available at: <http://scholarship.law.nd.edu/ndjlepp/vol14/iss1/8>

III. Монгол Улсын шүүгчдээс авсан асуулгын дүн

Судалгааны ажлын зорилго

Энэхүү санал асуулгын судалгаагаар “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийн байдал, үр нөлөөний талаар үнэлэлт, дүгнэлт өгөх зорилготой болно.

Судалгааны арга, аргачлал

Асуулгын буюу анкетын арга: Мэдээлэл цуглуулах үндсэн арга болно. Судалгааны мэдээллийг шүүхийн тамгын газраар дамжуулж шүүгчдийг бусдын нөлөөлөлд автахгүй, өөрийн үзэл бодлоо нээлттэй, шударгаар илэрхийлэх боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх замаар цуглуулсан бөгөөд мэдээллийн дан хийгээд харьцуулсан үр дүнг нийгмийн судалгааны SPSS програм дээр боловсруулав.

Судалгааны хамрах хүрээ ба түүвэрлэлт

Санал асуулгын судалгаанд Монгол Улсын давж заалдах болон анхан шатны бүх шүүхийн нийт 393 шүүгч хамрагдсан байна. Үүнд:

Хүснэгт №1. Түүврийн хэмжээ

| № | Тамгын газар | Шүүгчийн тоо |
|----------|--|---------------------|
| 1. | Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар | 12 |
| 2. | Хэнтий аймаг дахь шүүхийн тамгын газар | 12 |
| 3. | Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | 4 |
| 4. | Сүхбаатар аймаг дахь шүүхийн тамгын газар | 9 |
| 5. | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар | 10 |
| 6. | Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар | 4 |
| 7. | Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар | 7 |
| 8. | Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газар | 10 |
| 9. | Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | 2 |
| 10. | Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар | 10 |
| 11. | Төв аймаг дахь шүүхийн тамгын газар | 11 |
| 12. | Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газар | 9 |
| 13. | Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | 2 |
| 14. | Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар | 9 |
| 15. | Баянхонгор аймаг дахь шүүхийн тамгын газар | 10 |
| 16. | Завхан аймаг дахь шүүхийн тамгын газар | 11 |
| 17. | Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | 4 |
| 18. | Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар | 11 |
| 19. | Ховд аймаг дахь давж заалдах, анхан шатны шүүхийн тамгын газар | 5 |
| 20. | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | 3 |
| 21. | Увс аймаг дахь шүүхийн тамгын газар | 8 |
| 22. | Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар | 12 |
| 23. | Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар | 17 |
| 24. | Булган аймаг дахь шүүхийн тамгын газар | 12 |
| 25. | Хөвсгөл аймаг дахь шүүхийн тамгын газар | 14 |
| 26. | Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүхийн тамгын газар | 6 |
| 27. | Дархан-Уул аймаг дахь анхан шатны шүүхийн тамгын газар | 11 |
| 28. | Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газар | 11 |
| 29. | Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар | 3 |
| 30. | Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | 3 |
| 31. | Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар | 25 |
| 32. | Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар | 8 |
| 33. | Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар | 27 |

| | | |
|-------------|---|------------|
| 35. | Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар | 20 |
| 36. | Багануур дүүргийн шүүхийн тамгын газар | 3 |
| 37. | Багахангай, Налайх дүүргийн шүүхийн тамгын газар | 6 |
| 38. | Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар | 14 |
| 39. | Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар | 18 |
| 40. | Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар | 20 |
| Нийт | | 393 |

Судалгааны үр дүн

ХЭЗБТХ-ийн хэрэгжилтийн байдал, үр нөлөөний талаар шүүгчдээс санал асуулгыг авахдаа ажилласан жилийн талаар мэдээллийг авсан. Санал асуулгад оролцсон шүүгчдийн 50 хувь нь 10-аас дээш жил, 13 хувь нь 6-10 жил, 11 хувь нь 3-6 жил, 22 хувь нь 1-3 жил, 4 хувь нь 1 хүртэлх жил тус тус ажилласан гэжээ. (График №1)

График №1. Шүүгчээр ажилласан жил





График №2. ХЭЗБТХ-ийн 44.4 дэх заалт бодитоор хэрэгжиж байгаа эсэх?




ХЭЗБТХ-ийн 44.4-т зааснаар “Шүүгч өөрийн нэр хүнд, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжихээс бусад зорилгоор мэргэжлийн болон төрийн бус бусад байгууллагад эвлэлдэн нэгдэхийг хориглоно” гэсэн энэ заалт бодитоор хэрэгжиж байгаа эсэх талаар шүүгчид үзэхдээ 79 хувь нь “тийм” буюу хэрэгжиж байна, 17 хувь нь “учир дутагдалтай” байна, 4 хувь нь “үгүй” буюу хэрэгжихгүй байна гэж хариулжээ. “Учир дутагдалтай” байна болон “үгүй” гэж хариулсан шүүгчдийн саналыг багцалж харуулбал:

- МХХ Хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийг дэмждэг ТББ гэж үзэх эсэх нь эргэлзээтэй;
- Хуульчдын холбооны гишүүн, хуульч эмэгтэйчүүдийн болон шүүгч эмэгтэйчүүдийн зэрэг холбооны гишүүнчлэл нь энэ заалтад нийцдэггүй;


- Дүрмээ зөрчиж үйл ажиллагаа явуулдаг;
- Үндсэн хуульд заасан хүний эрхийг хэт хязгаарлаж байна;
- Энэ талаар судалсан бодит судалгаа байхгүй байна.

График №3. ХЭЗБТХ-ийн 44.6 дэх заалт бодитоор хэрэгжиж байгаа эсэх?



ХЭЗБТХ-ийн 44.6-т зааснаар “Хуульчдын их хурлын төлөөлөгчдийн 40 хувь нь шүүгч, прокурорын дундын төлөөлөл байна” гэсэн заалт бодитоор хэрэгжиж байгаа эсэх талаар шүүгчид үзэхдээ 53 хувь нь “хэрэгжиж байна”, 42 хувь нь “учир дутагдал” байна, 5 хувь нь “хэрэгжихгүй байна” гэж үзжээ. Харин учир дутагдалтай байгаа шалтгааныг дараах байдлаар байна гэж үзжээ.

График №4. Учир дутагдалтай байгаа шалтгаан



Шүүгч нар ХЭЗБТХ-ийн 44.6-т зааснаар “Хуульчдын их хурлын төлөөлөгчдийн 40 хувь нь шүүгч, прокурорын дундын төлөөлөл байна” гэсэн заалтыг цаашид “40 хувийн квотыг нэмэгдүүлэх шаардлагатай” гэж 40 хувь нь, “40 хувь сонгох процессыг сайжруулах” гэж 37 хувь нь үзсэн бол “40 хувийн квотыг багасгах” гэж 4 хувь, бусад шалтгаантай байна гэж 11 хувь нь үзсэн байна.

Хүснэгт №2. Хүснэгтэд байх заалтууд шүүгчийн хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэх

| № | ХЭЗБТХ-ийн холбогдох зүйл, заалтууд | Тийм | Үгүй |
|----|---|-------|-------|
| 1. | Хуульчдын холбооны Ерөнхийлөгч нь Хуульчдын холбооны шүүгчдийн хорооны удирдах зөвлөлөөс өргөн мэдүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс сонгож, Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгох үүрэгтэй. /ХЭЗБТХ-ийн 47.3.5 / | 38.1% | 61.9% |
| 2. | Хуульчдын холбооны хяналтын зөвлөл нь шүүгч, прокурор, өмгөөлөгчөөс бүрдсэн таван гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийг гурван жилийн хугацаагаар томилно. /ХЭЗБТХ-ийн 51.2/ | 33.9% | 66.1% |

| | | | |
|----|---|-------|-------|
| 3. | Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо нь Хуульчдын холбооны шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны гишүүд, түүнчлэн хуульч профессоруудын төлөөлөл оролцсон 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Мөн 52.2-т зааснаар Шалгалтын хорооны бүрэлдэхүүнийг Хуульчдын холбооны Зөвлөл батална. /ХЭЗБТХ-ийн 52.1/ | 31.5% | 68.5% |
| 4. | Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны гишүүн нь бүх шатны шүүгчид нэр дэвшиж байгаа хуульч болон Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр нэр дэвшиж байгаа шүүгч, прокурор, өмгөөлөгчийн зан байдлын талаар дүгнэлт гаргах шинжээчээр ажиллаж болно. /ХЭЗБТХ-ийн 54.3/ | 57.8% | 42.2% |
| 5. | Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо нь Хуульчдын холбооны шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн болон бусад мэргэшлийн чиглэлээр байгуулагдсан хуульчдын хорооны төлөөлөгчдөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Мөн зүйлийн 56.2-т Хуульчдын эрхийг хамгаалах хороонд шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны төлөөлөл тус бүр гурав, бусад хуульчдын хороодын нийт төлөөлөл дөрөв байна. Мөн 56.5-д зааснаар Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран комисс байгуулна. /ХЭЗБТХ-ийн 56.1/ | 38.6% | 61.4% |
| 6. | Шүүхийн ерөнхий зөвлөлөөс байгуулагдсан мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд Хуульчдын холбооны төлөөлөл орно. Мөн 60.2-т Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.2-т заасны дагуу Шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Хуульчдын холбоо гаргана. /ХЭЗБТХ-ийн 60.1/ | 55.4% | 44.6% |
| 7. | Мэргэжлийн хариуцлагын хороо нь маргааныг таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх ба бүрэлдэхүүнд шүүгч гурав, прокурор, өмгөөлөгч тус бүр нэг байна. Мөн 64.5.2, 64.6 Мэргэжлийн хариуцлагын хороо шүүгчийн Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн тухай болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэнтэй холбоотой үүссэн маргааныг бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч гаргана. /ХЭЗБТХ-ийн 63.8/ | 51.7% | 48.3% |

Шүүгчдээс ХЭЗБТХ-ийн хүснэгтэд дурдсан тодорхой хэдэн заалтуудын талаар шүүгчийн хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэх талаар тодруулахад хүснэгтийн цэнхэр хэсэгт байх заалтуудыг “нөлөөлж байна” гэж, ногоон хэсэгт байх заалтуудыг “нөлөөлөхгүй байна” гэж дийлэнх нь үзсэн байна.


Шүүгчийн хараат бус байдалд дараах заалтуудыг нөлөөлж байна гэж судалгаанд оролцсон шүүгчдийн олонх нь үзжээ. Үүнд:

- *Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны гишүүн нь бүх шатны шүүгчид нэр дэвшиж байгаа хуульч болон Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр нэр дэвшиж байгаа шүүгч, прокурор, өмгөөлөгчийн зан байдлын талаар дүгнэлт гаргах шинжээчээр ажиллаж болно. /ХЭЗБТХ-ийн 54.3/*
- *Шүүхийн ерөнхий зөвлөлөөс байгуулагдсан мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд Хуульчдын холбооны төлөөлөл орно. Мөн 60.2-т Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.2-т заасны дагуу Шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Хуульчдын холбоо гаргана. /ХЭЗБТХ-ийн 60.1/*
- *Мэргэжлийн хариуцлагын хороо нь маргааныг таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх ба бүрэлдэхүүнд шүүгч гурав, прокурор,*

өмгөөлөгч тус бүр нэг байна. Мөн 64.5.2, 64.6 Мэргэжлийн хариуцлагын хороо шүүгчийн Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн тухай болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэнтэй холбоотой үүссэн маргааныг бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч гаргана. /ХЭЗБтХ-ийн 63.8/

Эцэст нь, шүүгчдээс шүүгчдийг Хуульчдын холбооны гишүүнчлэлтэй байхыг дэмждэг эсэх талаар тодруулахад судалгаанд оролцсон шүүгчдийн 63 хувь нь “дэмждэггүй”, 24 хувь нь “дэмждэг” гэсэн бол 13 хувь нь одоогоор “хэлж мэдэхгүй байна” гэж хариулсан байна. (График №5)

График №5. Шүүгчид Хуульчдын холбооны гишүүнчлэлтэй байхыг дэмждэг эсэх



Судалгаанд оролцсон шүүгчдийн дийлэнх нь шүүгчид Хуульчдын холбоонд гишүүнчлэлтэй байхыг “дэмжихгүй байна” гэсэн бөгөөд тэд шалтгааныг дараах байдлаар бичгээр саналаа гаргасан байна. Үүнд:

- Хараат бус байдалд нөлөөлөх боломжтой – 23 санал;
- Шүүгчээр ажиллаж байх хугацаанд гишүүнчлэлийг нь түдгэлзүүлэх нь зүйтэй гэж үзэж байна – 13 санал;
- Шаардлагагүй гэж үздэг. Шүүгчид өөрсдөө бие даасан холбоонд харьяалагддаг бөгөөд бусад хуульч нартай нэг холбоонд харьяалалтай байгаа өөрөө шүүгчийн бие даасан хараат бус байдалд нөлөөлөх болно;
- Шүүхийн бие даасан, шүүхийн хараат бус байдлыг хангах чиг үүрэгтэй ШЕЗ ажиллаж байхад дахин өөр холбоонд харьяалагдах зохисгүй болов уу;
- Хуульчийн гэрчилгээг “Хуульчдын холбооны гишүүнээр элссэн тул олгов” гэж олгож буй нь “үндэслэлгүй”: ТББ-ын гишүүн гэдгээр биш хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж тусгай зөвшөөрлийг тусгай шалгуур шаардлагыг хангаж авдаг;
- Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах үүрэгтэй байгууллага байхад давхардуулах нь зохисгүй;
- Хуульчдын холбооны гишүүн шүүгч байх нь зохимжгүй бөгөөд манайхаас өөр хаана ч ийм тогтолцоо байдаггүй. Шүүгчдийн холбоо тусдаа байх ёстой;
- Олон улсын жишигт нийцэхгүй, дэмжихгүй;
- Шүүх хуралдааны оролцогч нартай хуульчдын холбоо, түүний хорооны үйл ажиллагаанд хамтран ажиллах нь шүүгчийн хараат бус байдалд зохих хэмжээгээр нөлөөлж байна гэж үздэг;
- Давхар хариуцлага хүлээлгэх (энэ зөрчилд) боломж үүсч байна;
- Хуульчдын холбоонд хэт хамааралтай болоод байна;
- Шүүх нь бие даасан статустай тул Хуульчдын холбооны гишүүн нарын доор өөрийн хараат бус байдал алдагдахад хүрч байгаа. Олон улсын практикт шүүх, хуульчдын холбооны гишүүн байдаггүй.

Дүгнэлт

Монгол Улсын бүх шатны шүүхийн шүүгчид Хуульчдын холбооны гишүүн байх нь шүүгчдийн эвлэлдэн нэгдэх эрхийн бодит илэрхийлэл байх бөгөөд дээр дурдсан олон улсын нийтээр дагаж мөрдөж буй хэм хэмжээнд нийцэж байна. Энэ хүрээнд шүүгчид Хуульчдын холбооны гишүүн байх, түүний үйл ажиллагаанд оролцох нь шүүх байгууллагын нэр төр, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах явдалд сөргөөр нөлөөлөх ёсгүй байна.

Гадаадын зарим улсад шүүгч нь Хуульчдын холбооны гишүүн байх эсэх асуудлыг төстэй байдлаар зохицуулсан байна. Тодруулбал, судалсан улсуудад ихэвчлэн шүүгчийг Хуульчдын холбооны гишүүн байхыг зөвшөөрөх хэдий ч шүүгчтэй холбоотой гомдлыг Хуульчдын холбоо бус Шүүхийн ёс зүйн хороо буюу түүнтэй адилтгах байгууллага, Ерөнхий шүүгч хариуцахаар зохицуулсан байна. Зарим судлаачийн хувьд шүүгчийг Хуульчдын холбооны гишүүнчлэлийг орхих нь зүйтэй гэх саналыг дэвшүүлсэн байдаг. Үүнийгээ Хуульчдын холбоон дахь гишүүнчлэл нь Шүүгчийн ёс зүйн дүрмээр хүлээсэн үүрэгтэй нь зөрчих эрсдэлтэй холбон тайлбарлажээ.

“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт ба хуульчдын холбоон дахь шүүгчдийн гишүүнчлэл, үйл ажиллагаа” сэдэвт лавлагааны хүрээнд Монгол Улсын анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт 393 шүүгчдээс санал асуулгын судалгааг гүйцэтгэж үр дүнг тайлагналаа. Судалгааны асуулгын үр дүнд ХЭЗБТХ-ийн хэрэгжилтийн байдал, үр нөлөөний талаар нарийвчилсан үнэлгээг хийсэн бөгөөд зарим асуулт, асуудлыг нэг бус удаа давтамжтай судалснаар илүү бодит үр дүнд хүрэх боломжтой юм. Дараах дүгнэлтүүдийг санал болгож байна.

- Шүүгчдийн 63 хувь нь шүүгчдийг Хуульчдын холбооны гишүүнчлэлтэй байхыг дэмжихгүй байна.
- Дэмжихгүй байх шалтгаан нь *“Хараат бус байдалд нөлөөлөх боломжтой” “Шүүгчээр ажиллаж байх хугацаанд гишүүнчлэлийг нь түдгэлзүүлэх нь зүйтэй”, “Олон улсын жишигт нийцэхгүй, дэмжихгүй”* зэрэг байна.
- ХЭЗБТХ-ийн холбогдох зүйл заалтаас дараах зүйл заалтыг шүүгчийн хараат бус байдалд **нөлөөлнө** гэж үзэж байна. Үүнд: *“Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны гишүүн нь бүх шатны шүүгчид нэр дэвшиж байгаа хуульч болон Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр нэр дэвшиж байгаа шүүгч, прокурор, өмгөөлөгчийн зан байдлын талаар дүгнэлт гаргах шинжээчээр ажиллаж болно” /ХЭЗБТХ-ийн 54.3/ “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс байгуулагдсан мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд Хуульчдын холбооны төлөөлөл орно. Мөн 60.2-т Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.2-т заасны дагуу Шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Хуульчдын холбоо гаргана” /ХЭЗБТХ-ийн 60.1/ “Мэргэжлийн хариуцлагын хороо нь маргааныг таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх ба бүрэлдэхүүнд шүүгч гурав, прокурор, өмгөөлөгч тус бүр нэг байна. Мөн 64.5.2, 64.6 Мэргэжлийн хариуцлагын хороо шүүгчийн Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн тухай болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэнтэй холбоотой үүссэн маргааныг бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч гаргана” /ХЭЗБТХ-ийн 63.8/ зэрэг заалтууд байна.*
- Мөн ХЭЗБТХ-ийн 44.4-т заасан *“Шүүгч өөрийн нэр хүнд, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжихээс бусад зорилгоор мэргэжлийн болон төрийн бус бусад байгууллагад эвлэлдэн нэгдэхийг хориглоно”* гэсэн заалтыг 79 хувь нь мөн хуулийн 44.6-т заасан *“Хуульчдын их хурлын төлөөлөгчдийн 40 хувь нь шүүгч, прокурорын дундын төлөөлөл байна”* гэсэн заалтыг 53 хувь нь бодит утгаараа хэрэгжиж байна гэж үзжээ.

Ном зүй

Гадаад хэл дээрх эх сурвалж:

- Basic Principles on the Independence of the Judiciary, 1985
- European Charter on the statute for judges (8-10 July 1998) and Explanatory Memorandum to the European Charter on the statute for judges (8- 10 July 1998)
- Montreal Universal Declaration on the Independence of Justice (the First World Conference on the Independence of Justice held at Montreal (Quebec, Canada) on June 10th, 1983)
- New York City Bar, *How to Complain about Lawyers and Judges in New York City*, June 2012, page 8
- Randall T. Shepard, *Judicial Professionalism and the Relations between Judges and Lawyers*, 14 Notre Dame J.L. Ethics & Pub. Pol'y 223 (2000).
- The Bangalore Principles of Judicial Conduct, 2002
- The Bylaws of the New York Bar Association
- The Universal Charter of the Judge (adopted by the International Association of Judges on 17 November 1999, Taipei (Taiwan))
- The American Bar Association
- The Canadian Bar Association
- Hong Kong Bar Association
- Israel Bar Association
- New Zeland Bar Association
- The Office of the Judicial Conduct Commissioner of New Zeland
- Guidelines for Judicial Conduct of New Zeland
- Guidelines for Complaints Against a Judge's Conduct of Hong Kong

Монгол хэл дээрх эх сурвалж:

- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012

